

**Монголбанкны Олон Нийтгэй Харилцах Хэлтсийн эдийн засагч**

**Э.ХИШИГЖАРГАЛ: МОНГОЛБАНК ЯМАР Ч ТОХИОЛДОЛД  
ИНФЛЯЦИЙГ ХЯНАЛТААС ГАРГАХГҮЙ**

**Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцийн үед Мөнгөний бодлогыг чангаруулах нь тийм ч зохимжтой арга хэмжээ биш гэдгийг эдийн засагчид ч болоод Монголбанкныхан өөрсдөө ч хэлдэг. Тэгсэн хэрнээ яагаад бодлогын хүүг нэмээд байна вэ?**

- Энэ оны 3-р сард инфляци Улаанбаатар хотын хэмжээнд 17.3 хувьд хүрсэн байгаа. Махны үнийн өсөлт инфляцийн 7.4 нэгж хувийг бүрдүүлж байна. Үүнийг Монголбанк нийлүүлэлтийн шок гэж үзэж байгаа юм. Нөгөө талаас эрэлтийн хүчин зүйлс инфляцийн дарамтыг сулруулахааргүй байгаа нь инфляцийн хүлээлтийг хөөргөж, үнийн өсөлтийн 2 дахь үеийн нөлөөг дагуулах эрсдэлтэй байсан тул бид мөнгөний бодлогыг хатууруулсан. Тэрнээс биш нийлүүлэлтээс үүдэлтэй инфляциас шалтгаалж бодлогын хүүг нэмсэн хэрэг биш.

**Засгийн газрын төсвийн хэт тэлэлт, халамжийн мөнгөө болиоч ээ гэж хүчтэй дуугарахын оронд Төвбанк Засгийн газарт 21000 төгрөг тараах санхүүжилтийн нэг бус удаа хийж байгаа нь хууль зөрчсөн хэрэг биш үү. Нэг үгээр хэлбэл, Төв банк муу хэлүүлэн байж авч хэрэгжүүлж байгаа Мөнгөний хатуу бодлогынхоо эсрэг зогсож байгаа юм биш үү?**

- Ямар ч байсан Монголбанк хуулийн хүрээнд ажилласан. Засгийн газар улирлын чанартай алдагдлаа Монголбанкнаас зээл авч хааж болдог. Хэрвээ Монголбанкнаас зээл авч 21 мянгаа тараагаагүй байсан бол нийгэмд ямар сөрөг нөлөө гарах байсныг бид бас бодож үзэх хэрэгтэй болов уу.

**Инфляцийг бодлогын хүүгээр намнадаг цаг өнгөрсөн. Эдийн засаг хүссэн хүсээгүй асар хурдацтай тэлж байна. 2008-2009 оны хямралын үеийнхээс нөхцөл байдал тэс өөр байсан. Ядуус нь хүртэл баян ядуус болсон. Бизнес хөгжиж мөнгө хэрэг болж байна. Ийм үед Монголбанкны мөнгөний бодлого өөр байх ёстой гэж үзэх хүн олон. Үнэхээр ч тийм. Энэ талаар юу хэлэх вэ?**

- Мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах шаардлага мэдээж байгаа. Гэхдээ мөнгөний бодлого илүү үр ашигтай хэрэгжихийн тулд төсвийн орчин зайлшгүй сахилга баттай байх учиртай. Гэтэл энэ жилийн төсөв өнгөрсөн жилийнхээс даруй 50 хувиар илүү батлагдсан. Уул уурхайн орлогыг хасвал төсвийн алдагдал ДНБ-ний 15%-д хүрэхээр байгаа. Төсвийн давамгайлал хэт их байгаа орчинд мөнгөний бодлого яалт ч үгүй хүчин мөхөстдөг. Монголбанк 2013 оноос хэрэгжих төсвийн тогтвортой байдлын тухай хуульд маш их ач холбогдол өгч байгаа. ДНБ-д төсвийн зарлагын хэмжээ зохистой түвшинд

очихоор инфляци тогтворжиж, мөнгөний бодлого сулрах бодит боломж бүрдэнэ гэдэгт итгэж байна.

**Мөнгөний хатуу бодлого бизнесийн салбарыг тэр дундаа жижиг дунд бизнесийг боомилж байна гэдэгтэй санал нийлэх үү? Хувийн хэвшлийн салбарт инфляци гэдэг хадны мангаа дээр Бодлогын хүү гэдэг мангастай боллоо гэсэн яриа гарах болжээ. Та үүнийг юу гэж үзэж байна вэ?**

- Та дээр эдийн засаг асар хурдацтай өсч байна гэлээ. Тэгвэл энэ хурдацтай өсөлтийн нэлээдгүй хэсгийг банкны зээл бүрдүүлж байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүнд зээлийн эзлэх хувь хэмжээг харвал 2009 онд 40.3 хувь, 2010 онд 38.8 хувьтай байсан бол 2011 онд 52.1 хувь болж өссөн үзүүлэлттэй байна. Аливаа мэдэгдэл тоо баримтанд тулгуурлах учиртай. ЖДҮ-ийн зээлийн хувьд гэхэд 2009 онд 222 тэрбум төгрөг, 2010 онд 239 тэрбум төгрөг, 2011 онд 417 тэрбум төгрөг байсан бол 2012 оны 1-р улирлын байдлаар 1.07 их наяд төгрөг болон өссөн үзүүлэлттэй байна. Эндээс харахад зээл буураагүй гэдэг нь харагдаж байгаа болов уу.

**Инфляцийн өсөлт эдийн засагт ямар их хор хохиролтой вэ гэдгийг мэдэхгүй биш мэдэж байгаа хэрнээ юман чинээ бодохгүй байгаа, бодохыг ч хүсэхгүй байгаа төр, засгийнхны дураараа авирлалын эсрэг Монголбанк инфляцитай тэмцэж байгаа ганц байгууллагын хувьд ч, Төвбанкны хувьд ч тэр хүчтэй дуу хоолой гаргаж болдоггүй юм уу. Гэтэл харин эсрэгээрээ өнөөдөр бизнесийн зээл хумигдаж, инфляци өсөхөд Монголбанк буруутай гэж хэвнэг өгүүлж буй төр, засгийн зарим хүний тайлбарт танай зүгээс ямар хариу өгөх вэ? Өт хүртэл чичихээр атирдаг шүү дээ?**

- Засгийн газрын шийдвэр төрийн мөнгөний бодлогод харшилж байвал Монголбанк энэ талаар Засгийн газарт мэдэгддэг хуультай. Энэ хүрээнд Төвбанк Засгийн газарт удаа дараа инфляцийн дарамт өсөх эрсдэлтэй байгааг анхааруулан, бэлэн мөнгө, тэтгэмж олгохоо зогсоох, махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар саналаа хүргүүлж байсан. Яахав, Засгийн газарт хаягласан албан тоотууд олон түмэнд ил биш байдаг болохоор Төвбанк дуугүй байгаа мэт ойлгогддог байх. Гэхдээ инфляци өссөнд дан ганц Засгийн газар буруугүй. Бүх зүйл 2 намын бэлэн мөнгөний амлалтаас эхэлсэн. Харин улс төрийн амлалт өгсөн эрх баригчдыг бид өөрсдөө л сонгосон шүү дээ.

**Төвбанкны хувьд сонгуулийн дараах инфляцийн түвшинг хэрхэн урьдчилан харж байгаа вэ. Мах шатахууны үнэ өнөөдрийн байгаагаас хямд байж чадах болов уу?**

- 2012 оны Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцийг нэг оронтой тоонд барина хэмээн тусгагдсан. Гэтэл 3 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотын инфляци жилийн 17.3 хувьд хүрсэн дүнтэй байна. Иймээс дарамт бол нэлээн өндөр байгаа. Зарим олон улсын байгууллагууд инфляци дараагийн хоёр жил 2 оронтой тоогоор илэрхийлэгдэнэ гэсэн таамаглалыг хэлсэн. Засгийн

газар инфляцийг 13.1%-аас хэтрэхгүй хэмээн зарласан. 7-р сараас бэлэн мөнгө тараах ажил эхнээсээ зогсож эхлэх байх. Ингээд 2013 оноос төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа чанд мөрдөөд эхэлбэл инфляцийн дарамт эрс суларна гэдэгт итгэж байна. Ямар ч тохиолдолд Монголбанк инфляцийг хяналтаас гаргахгүй ба түүний эсрэг зохих арга хэмжээг цаг алдалгүй авах болно гэдгийг хэлмээр байна.